



**ОРХОН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

61033 Орхон аймаг, Баян-Өндөр сум,
Урт булаг баг, Ханддоржийн
гудамж, Утас/Факс: 70359826
Цахим шуудан: orkhon@audit.gov.mn

2025.02.24 № 104
танай _____-ны № _____-т

ОРХОН АЙМАГ ДАХЬ БҮСИЙН
ОНОШЛОГОО ЭМЧИЛГЭЭНИЙ
ТӨВИЙН ЗАХИРАЛ Ц.НАРАН-
ЭРДЭНЭ ТАНАА

**2024 оны санхүүгийн тайлангийн
аудитын тухай**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3-д заасан бүрэн эрхийн хүрээнд Орхон аймаг дахь бүсийн оношлогоо эмчилгээний төвийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг түүвэрт хамруулан, баталгаажуулах аудит хийлээ.

Аудитаар нийт 50,109.4 мянган төгрөгийн зөрчил илэрч, аудитаар илрүүлсэн зөрчлийн асуудлын бүртгэл хөтлөн баталгаажуулж, 2,266.9 мянган төгрөгийн зөрчилд 2 төлбөрийн акт, 47,842.4 мянган төгрөгийн зөрчилд 3 албан шаардлага өгч байна.

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5-д “Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ.” гэж заасныг хэрэгжүүлж төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн мөрөөр хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг 30 хоногийн дотор, төлбөрийн актыг бүрэн барагдуулж, зөвлөмжийн биелэлтийг 2025 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн дотор тус тус ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

П.ПҮРЭВЛХАГВА

ОРХОН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Орхон аймаг дахь Бүсийн оношлогоо эмчилгээний төвийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: ОРА-2025/110/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.audit.mn

Орхон аймаг
2025 он

Орхон аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор: П.Пүрэвлхагва
Утас: 70353088 Цахим хаяг: purevlkhagvap@audit.gov.mn

Аудитын менежер: Б.Буян-Ундрах
Утас: 70355805 Цахим хаяг: buyanundrakhb@audit.gov.mn

Ахлах аудитор: Т.Болормаа
Утас: 70357855 Цахим хаяг: bolormaat@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1. Хараат бус аудиторын дүгнэлт
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл
3. Санхүүгийн тайлангийн тодруулга.....
 - 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа.....
 - 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин.....
 - 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал
 - 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт
4. Аудитын тайлан.....
 - 4.1 Ерөнхий зүйл
 - 4.2 Материаллаг байдал
 - 4.3 Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилт.....
 - 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал
 - 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт
 - 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал
5. Аудитын илрүүлэлт
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар



**ОРХОН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

61033 Орхон аймаг, Баян-Өндөр сум,
Урт булаг баг, Ханддоржийн
гудамж, Утас/Факс: 70359826
Цахим шуудан: orkhon@audit.gov.mn

2025.02.24 № 56
танай _____-ны № _____-т

ОРХОН АЙМАГ ДАХЬ БҮСИЙН
ОНОШЛОГОО ЭМЧИЛГЭЭНИЙ
ТӨВИЙН ЗАХИРАЛ
Ц.НАРАН-ЭРДЭНЭ ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Тайлант онд татаас санхүүжилтийн авлага 2,774.5 сая төгрөг, өглөг 3,334,953.8 мянган төгрөгийн өглөг бүртгэлтэй байгаа нь төсвийн зарлагыг орлого болон санхүүжүүлэх бусад эх үүсвэрээр нь бүрэн нөхдөг байхаар төлөвлөн баталж, хэрэгжүүлэх зарчим алдагдах эрсдэлтэй байна.

Аудитын гол асуудал

Эрүүл мэндийн салбарын 2022-2023 оны хамтын хэлэлцээрийн 3.16-д “Ажил олгогч нь эрүүл мэндийн салбар хариуцлагатай албан тушаал болох тасгийн эрхлэгч, ахлах сувилагч нарт хариуцлагын нэмэгдлийг үндсэн цалингийн 10-аас доошгүй хувиар, эд хөрөнгийн бүрэн хариуцлагын гэрээтэй эд хариуцлагын гэрээтэй эд хариуцагч нарт үндсэн цалингийн 8-аас доошгүй хувийн нэмэгдэл хөлс олгох эрх зүйн орчныг бүрдүүлэн хэрэгжүүлнэ”, Эрүүл мэндийн сайдын 2020 онд баталсан

“Хамтын хэлэлцээрийн хэрэгжилтийг хангах тухай” А/69 дүгээр тушаалын 1.9-т “Эрүүл мэндийн салбар хариуцлагатай албан тушаал болох тасгийн эрхлэгч, ахлах сувилагч нарт хариуцлагын нэмэгдлийг үндсэн цалингийн 10-аас доошгүй хувиар, эд хөрөнгийн бүрэн хариуцлагын гэрээтэй эд хариуцагч нарт үндсэн цалингийн 8-аас доошгүй хувийн нэмэгдэл олгох” гэж заасны дагуу 35,689.2 мянган төгрөгийг цалингийн зардлаас олгосон байна.

Энэ нь Засгийн газрын 2019 оны 05 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтаар баталсан “төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам”-ын Гурав. “Эрүүл мэндийн ажилтанд улирлын үр дүнгээр олгох мөнгөн урамшуулал”-ын үр дүнгийн үндсэн шалгуур, үндсэн шалгуурыг тодорхойлох тусгай үзүүлэлттэй давхардуулан дүгнэж, үр дүнгийн урамшуулалтай давхардуулан олгосон байна.

Бусад асуудлын хэсэг

Тайлант онд Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн 2024 оны 06 дугаар тогтоолоор “Эрүүл мэндийн даатгалын сангаас зардлын төлбөрийг нь хариуцах эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний оношийн хамааралтай бүлгийн жагсаалт, төлбөрийн хэмжээ”-нд өөрчлөлт орсон байна.

Тухайн аудитыг хийх явцад аудитын дүгнэлт, тайлантай холбогдуулан аудит гүйцэтгэж буй төрийн аудитын албан хаагчид аливаа этгээдээс зүй бусаар нөлөөлөх нөлөөлөл, мэдээллийн нууцлал, ашиг сонирхол, ёс зүйтэй холбоотой холбогдох хуулийн дагуу мэдэгдлүүдийг гарган баталгаажуулсан болно.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



П.ПҮРЭВЛХАГВА

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын зүйл	Тодруулга	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН		8,293,482,062.48	6,827,835,127.45
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ		227,708,697.49	997,175,293.65
312	Банкинд байгаа бэлэн мөнгө		227,708,697.49	997,175,293.65
3121	Төгрөг		227,708,697.49	997,175,293.65
31211	Төрийн сангийн харилцах		227,708,697.49	997,175,293.65
33	АВЛАГА		5,291,889,330.00	2,774,465,733.30
33300	Татаас, санхүүжилтийн авлага		5,291,889,330.00	2,774,465,733.30
35	БАРАА МАТЕРИАЛ		2,773,884,034.99	3,056,194,100.50
351	Түүхий эд материал		1,476,873,359.60	1,546,560,825.60
35110	Тусгай зориулалттай материал		1,072,020,147.63	971,167,015.67
35130	Эм боох материал		404,853,211.97	575,393,809.93
354	Хангамжийн материал		1,297,010,675.39	1,509,633,274.90
35440	Түлш, шатах тослох материал		3,459,843.29	5,411,136.90
35450	Барилгын засварын материал		1,273,420,617.10	1,486,694,633.00
35460	Хүнсний материал		5,468,015.00	12,990,500.00
35470	Бусад хангамжийн материал		14,662,200.00	4,537,005.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН		33,376,113,165.55	31,790,559,649.52
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ		33,376,113,165.55	31,790,559,649.52
392	Биет хөрөнгө		30,512,393,165.55	28,926,839,649.52
39201	Барилга, байгууламж, орон сууц		25,943,002,111.03	26,058,941,004.03
39202	Хуримтлагдсан элэгдэл		-4,967,694,504.86	-6,060,848,266.45
39203	Авто-тээврийн хэрэгсэл		927,048,161.00	1,474,368,083.20
39204	Хуримтлагдсан элэгдэл		-610,363,841.77	-722,685,773.40
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)		19,235,953,264.05	20,347,760,304.51
39206	Хуримтлагдсан элэгдэл		-10,538,629,761.65	-12,595,751,185.94
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил		534,328,194.83	357,843,125.57
39208	Хуримтлагдсан элэгдэл		-349,641,803.96	-228,476,836.24
39214	Бусад үндсэн хөрөнгө		730,545,579.00	732,995,579.00
39215	Хуримтлагдсан элэгдэл		-392,154,232.12	-437,306,384.76
393	Биет бус хөрөнгө		2,863,720,000.00	2,863,720,000.00
39301	Програм хангамж		9,883,087.00	9,883,087.00
39302	Хуримтлагдсан элэгдэл		-9,883,087.00	-9,883,087.00
39303	Бусад биет бус хөрөнгө		2,863,720,000.00	2,863,720,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II		41,669,595,228.03	38,618,394,776.97
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР		4,050,313,138.68	3,379,201,282.29
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР		4,050,313,138.68	3,379,201,282.29
413	Өглөг		4,050,313,138.68	3,379,201,282.29
41310	Ажилчидтай холбогдсон өглөг		484,889,579.02	217,117,447.30
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг		2,217,838,007.11	2,761,606,099.99
4136	Бусад өглөг		1,347,585,552.55	400,477,735.00
41361	Байгууллагад төлөх өглөг		1,341,980,752.55	398,719,735.00
41362	Хувь хүмүүст төлөх өглөг		5,604,800.00	1,758,000.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН		37,619,282,089.35	35,239,193,494.68
51	Засгийн газрын хувь оролцоо		37,619,282,089.35	35,239,193,494.68
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан		10,297,152,047.96	10,297,152,047.96
51101	Өмч: - төрийн		10,297,152,047.96	10,297,152,047.96

512	Хуримтлагдсан үр дүн		7,420,285,484.93	5,040,196,890.26
51210	Өмнөх үеийн үр дүн		11,640,101,230.25	7,606,186,482.03
51220	Тайлант үеийн үр дүн		-4,219,815,745.32	-2,565,989,591.77
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү		19,901,844,556.46	19,901,844,556.46
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V		41,669,595,228.03	38,618,394,776.97

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Балансын зүйл	Тодруулга	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)		25,931,559,051.82	32,835,368,855.86
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО		4,643,399,211.82	6,762,138,486.86
120	Нийтлэг татварын бус орлого		4,643,399,211.82	6,762,138,486.86
120004	Төсөвт байгууллагын өөрийн орлого		3,499,186,581.03	5,380,107,700.46
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих		710,630,717.38	781,454,384.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих		1,954,486,292.94	3,577,473,257.66
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого- бараа материал		834,069,570.71	1,021,180,058.80
122	ТУСЛАМЖИЙН ОРЛОГО		1,144,212,630.79	1,382,030,786.40
122002	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-үндсэн хөрөнгө		1,144,212,630.79	1,382,030,786.40
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО		21,288,159,840.00	26,073,230,369.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих		21,288,159,840.00	26,073,230,369.00
134003	Нийгмийн даатгалын сангаас эмнэлгүүдэд олгох санхүүжилт		21,288,159,840.00	26,073,230,369.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН		30,151,374,797.14	35,401,358,447.63
21	УРСГАЛ ЗАРДАЛ		30,151,374,797.14	35,401,358,447.63
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		30,124,610,797.14	34,863,644,101.38
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил		15,221,579,122.24	18,550,879,062.94
210101	Үндсэн цалин		7,358,991,116.84	8,391,756,234.88
210102	Нэмэгдэл цалин		6,553,986,456.88	8,476,266,838.20
210103	Унаа хоолны хөнгөлөлт		375,590,348.52	894,482,768.62
210104	Урамшуулал		933,011,200.00	788,373,221.24
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл		1,901,905,856.10	3,242,186,420.00
210201	Тэтгэврийн даатгал		1,251,909,875.56	2,310,331,529.60
210202	Тэтгэмжийн даатгал		153,548,532.16	232,969,197.60
210203	ҮОМШ өвчний даатгал		183,442,649.97	131,128,878.08
210204	Ажилгүйдлын даатгал		29,503,220.49	101,851,319.52
210205	Эрүүл мэндийн даатгал		283,501,577.92	465,905,495.20
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал		807,330,116.98	905,705,053.74
210301	Гэрэл цахилгаан		355,678,337.89	382,682,658.37
210302	Түлш, халаалт		226,627,527.09	303,559,864.16
210303	Цэвэр, бохир ус		225,024,252.00	219,462,531.21
2104	Хангамж, бараа материалын зардал		533,273,071.81	521,112,163.80
210401	Бичиг хэрэг		47,749,150.00	26,887,960.00
210402	Тээвэр шатахуун		152,567,920.95	143,628,944.84
210403	Шуудан холбоо, интернэтийн төлбөр		20,748,051.10	17,972,500.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал		57,843,428.00	44,771,985.00

210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	108,116,820.00	108,000,000.00
210408	Бараа материал акталсны зардал	146,247,701.76	179,850,773.96
2105	Нормативт зардал	7,441,055,111.42	7,048,084,010.18
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	6,824,660,956.42	6,503,995,902.18
210502	Хоол, Хүнс	602,319,725.00	520,877,563.00
210503	Нормын болон дүрэмт хувцас, зөөлөн эдлэл	14,074,430.00	23,210,545.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	709,682,620.00	1,204,742,503.65
210604	Урсгал засвар	709,682,620.00	1,204,742,503.65
2107	Томилолт, зочны зардал	14,813,800.00	18,175,900.00
210702	Дотоод албан томилолт	14,813,800.00	18,175,900.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	225,754,470.14	109,012,727.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	136,044,457.14	27,169,887.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	1,300,000.00	962,640.00
	Тээврийн хэрэгслийн даатгал	7,000,000.00	7,000,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	605,000.00	495,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	9,600,000.00	13,000,000.00
210807	Газрын төлбөр	26,786,280.00	22,885,200.00
	Улсын мэдээллийн маягт хэвлэх бэлтгэх зардал	44,418,733.00	37,500,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	3,269,216,628.45	3,263,746,260.07
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	0.00	25,061,957.64
210902	Хичээл үйлвэрлэлийн дадлага хийх	2,740,000.00	52,100,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл хорогдлын зардал	3,266,476,628.45	3,186,584,302.43
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	26,764,000.00	537,714,346.25
2132	Бусад урсгал шилжүүлэг	26,764,000.00	457,644,400.00
213208	ХОН-т тогтвор суурьшилтэй ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	0.00	383,526,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	26,764,000.00	74,118,400.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	0.00	80,069,946.25
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	0.00	80,069,946.25
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	-4,219,815,745.32	-2,565,989,591.77
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	-4,219,815,745.32	-2,565,989,591.77

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Тодруулга	Өмнөх оны дүн	Тайлант жилийн дүн
0	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		0.00	0.00
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)		21,698,007,120.32	32,949,581,607.36
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО		782,630,717.38	853,454,384.00
120	Нийтлэг татварын бус орлого		782,630,717.38	853,454,384.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого		782,630,717.38	853,454,384.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих		710,630,717.38	781,454,384.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих		72,000,000.00	72,000,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО		20,915,376,402.94	32,096,127,223.36
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих		438,200,000.00	2,307,832,072.66
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/		438,200,000.00	2,307,832,072.66

1330	Төсвийн захирагчдаас		1,444,286,292.94	1,197,641,185.00
133005	Төсвийн ерөнхийлөн захирагч хооронд хийсэн санхүүжилт		1,444,286,292.94	1,197,641,185.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих		19,032,890,110.00	28,590,653,965.70
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих		19,032,890,110.00	28,590,653,965.70
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН		24,083,775,715.74	32,180,115,011.20
21	УРСГАЛ ЗАРДАЛ		24,083,775,715.74	32,180,115,011.20
210	БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		24,054,794,715.74	31,639,894,664.95
2101	Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил		14,916,088,824.04	18,818,651,194.66
210101	Үндсэн цалин		7,053,500,818.64	8,659,528,366.60
210102	Нэмэгдэл		6,553,986,456.88	8,476,266,838.20
210103	Унаа хоолны Хөнгөлөлт		375,590,348.52	894,482,768.62
210104	Урамшуулал		933,011,200.00	788,373,221.24
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл		1,722,506,575.28	3,242,186,420.00
210201	Тэтгэврийн даатгал		1,129,918,364.60	2,310,331,529.60
210202	Тэтгэмжийн даатгал		139,196,589.69	232,969,197.60
210203	ҮОМШӨ-ний даатгал		171,961,096.00	131,128,878.08
210204	Ажилгүйдлийн даатгал		26,632,832.00	101,851,319.52
210205	Эрүүл мэндийн даатгал		254,797,692.99	465,905,495.20
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал		718,385,107.02	994,650,063.70
210301	Гэрэл, цахилгаан		319,989,285.89	418,371,710.37
210302	Түлш, халаалт		192,000,351.13	338,187,040.12
210303	Цэвэр, бохир ус		206,395,470.00	238,091,313.21
2104	Хангамж, бараа материалын зардал		349,818,270.71	339,125,897.95
210401	Бичиг хэрэг		36,852,600.00	27,097,300.00
210402	Тээвэр, шатахуун		145,863,899.61	143,728,597.95
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр		20,863,051.10	18,000,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал		38,121,900.00	42,300,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс		108,116,820.00	108,000,000.00
2105	Нормативт зардал		4,693,529,200.00	6,495,615,960.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл		4,133,967,400.00	5,865,310,802.00
210502	Хоол, хүнс		520,000,000.00	596,780,908.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл		39,561,800.00	33,524,250.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал		1,418,846,968.55	1,524,881,549.00
210601	Багаж, техник, хэрэгсэл		607,376,176.55	921,239,700.00
210604	Урсгал засвар		811,470,792.00	603,641,849.00
2107	Томилолт, зочны зардал		14,813,800.00	18,175,900.00
210702	Дотоод албан томилолт		14,813,800.00	18,175,900.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		218,013,970.14	114,982,927.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж		128,303,957.14	40,405,287.00
210803	Даатгалын үйлчилгээ		7,000,000.00	7,000,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар		1,300,000.00	962,640.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо		605,000.00	495,000.00

210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ		9,600,000.00	13,000,000.00
210807	Газрын төлбөр		26,786,280.00	15,620,000.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх		44,418,733.00	37,500,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал		2,792,000.00	91,624,752.64
210901	Бараа үйлчилгээний бусад зардал		0.00	39,524,752.64
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх		2,792,000.00	52,100,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		28,981,000.00	540,220,346.25
2132	Бусад урсгал шилжүүлэг		28,981,000.00	460,150,400.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтэй ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг		0.00	383,526,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал		28,981,000.00	76,624,400.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт		0.00	80,069,946.25
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг		0.00	80,069,946.25
	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДАЛ		1,529,132,176.00	219,000,000.00
	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ		1,529,132,176.00	219,000,000.00
	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал		1,529,132,176.00	219,000,000.00
	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		-1,529,132,176.00	-219,000,000.00
	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ		-1,529,132,176.00	-219,000,000.00
	Бусад зардал		-1,529,132,176.00	-219,000,000.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)		-2,385,768,595.42	769,466,596.16
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		-2,385,768,595.42	769,466,596.16
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		2,613,477,292.91	227,708,697.49
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		227,708,697.49	997,175,293.65

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан үр дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
4-01	2022 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	10,297,152,047.96	19,901,844,556.46	11,640,101,230.25	41,839,097,834.67
4-03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	10,297,152,047.96	19,901,844,556.46	11,640,101,230.25	41,839,097,834.67
4-08	Тайлант үеийн үр дүн	-	-	(4,219,615,745.32)	(4,219,615,745.32)
4-01	2023 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	10,297,152,047.96	19,901,844,556.46	7,420,285,484.93	37,619,282,089.35
4-02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	185,900,997.10	185,900,997.10
4-03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	10,297,152,047.96	19,901,844,556.46	7,606,186,482.03	37,805,183,086.45
4-08	Тайлант үеийн үр дүн	-	-	(2,565,989,591.77)	(2,565,989,591.77)
4-01	2024 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	10,297,152,047.96	19,901,844,556.46	5,040,196,890.26	35,239,193,494.68

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэл	Зөрүү	Хувь
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00	227,708,697.49	-227,708,697.49	0.00
НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	27,650,198,308.00	31,211,733,311.20	3,561,535,003.20	0.00
УРСГАЛ ЗАРДАЛ	27,650,198,308.00	31,211,733,311.20	3,561,535,003.20	0.00
БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	27,187,497,908.00	30,734,189,611.21	3,546,691,703.21	0.00
Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	15,785,062,800.00	18,818,651,194.66	3,033,588,394.66	0.00
Үндсэн цалин	8,850,814,900.00	8,659,528,366.60	191,286,533.40	0.00
Нэмэгдэл цалин	5,088,272,800.00	8,476,266,838.20	3,387,994,038.20	0.00
Унаа хоолны Хөнгөлөлт	636,367,200.00	894,482,768.62	-258,115,568.62	0.00
Урамшуулал	1,209,607,900.00	788,373,221.24	421,234,678.76	0.00
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	3,242,284,000.00	3,242,186,420.00	97,580.00	0.00
Тэтгэврийн даатгал	2,310,350,000.00	2,310,331,529.60	18,470.40	0.00
Тэтгэмжийн даатгал	232,989,000.00	232,969,197.60	19,802.40	0.00
ҮОМШӨ-ний даатгал	131,144,700.00	131,128,878.08	15,821.92	0.00
Ажилгүйдлийн даатгал	101,855,300.00	101,851,319.52	3,980.48	0.00
Эрүүл мэндийн даатгал	465,945,000.00	465,905,495.20	39,504.80	0.00
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	88,945,100.00	88,945,009.96	90.04	0.00
Гэрэл, цахилгаан	35,689,100.00	35,689,052.00	48.00	0.00
Түлш, халаалт	34,627,200.00	34,627,175.96	24.04	0.00
Цэвэр, бохир ус	18,628,800.00	18,628,782.00	18.00	0.00
Хангамж, бараа материалын зардал	344,133,600.00	339,125,897.95	5,007,702.05	0.00
Бичиг хэрэг	29,667,000.00	27,097,300.00	2,569,700.00	0.00
Тээвэр, шатахуун	146,166,600.00	143,728,597.95	2,438,002.05	0.00
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	18,000,000.00	18,000,000.00	0.00	0.00
Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	42,300,000.00	42,300,000.00	0.00	0.00
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	108,000,000.00	108,000,000.00	0.00	0.00
Нормативт зардал	6,496,192,308.00	6,495,615,960.00	576,348.00	0.00
Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	5,865,460,600.00	5,865,310,802.00	149,798.00	0.00
Хоол, хүнс	596,780,908.00	596,780,908.00	0.00	0.00
Нормын хувцас, зөөлөн эдлэл	33,950,800.00	33,524,250.00	426,550.00	0.00
Эд хогшил, урсгал засварын зардал	939,573,300.00	1,524,881,549.00	-585,308,249.00	0.00
Багаж, техник, хэрэгсэл	921,239,700.00	921,239,700.00	0.00	0.00
Урсгал засвар	18,333,600.00	603,641,849.00	-585,308,249.00	0.00
Томилолт, зочны зардал	18,333,600.00	18,175,900.00	157,700.00	0.00

Дотоод албан томилолт	18,333,600.00	18,175,900.00	157,700.00	0.00
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	164,700,000.00	114,982,927.00	49,717,073.00	0.00
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	89,630,000.00	40,405,287.00	49,224,713.00	0.00
Даатгалын үйлчилгээ	7,000,000.00	7,000,000.00	0.00	0.00
Тээврийн хэрэгслийн татвар	1,300,000.00	962,640.00	337,360.00	0.00
Тээврийн хэрэгслийн оношилгоо	650,000.00	495,000.00	155,000.00	0.00
Мэдээлэл, технологийн үйлчилгээ	13,000,000.00	13,000,000.00	0.00	0.00
Газрын төлбөр	15,620,000.00	15,620,000.00	0.00	0.00
Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	37,500,000.00	37,500,000.00	0.00	0.00
Бараа үйлчилгээний бусад зардал	108,273,200.00	91,624,752.64	16,648,447.36	0.00
Бараа үйлчилгээний бусад зардал	56,173,200.00	39,524,752.64	16,648,447.36	0.00
Хичээл үйлдвэрлэлийн дадлага	52,100,000.00	52,100,000.00	0.00	0.00
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	462,700,400.00	460,150,400.00	2,550,000.00	0.00
Бусад урсгал шилжүүлэг	462,700,400.00	460,150,400.00	2,550,000.00	0.00
ХОН-т тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	383,526,000.00	383,526,000.00	0.00	0.00
Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	79,174,400.00	76,624,400.00	2,550,000.00	0.00
Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	0.00	17,393,299.99	-17,393,299.99	0.00
Төвлөрүүлэх шилжүүлэг	0.00	17,393,299.99	-17,393,299.99	0.00
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	36,252,433,457.66	32,949,581,607.36	3,302,851,850.30	
ЭМД-ААС САНХҮҮЖИХ	32,887,172,900.00	28,590,653,965.70	4,296,518,934.30	0.00
Эрүүл мэндийн даатгалаас	32,887,172,900.00	28,590,653,965.70	4,296,518,934.30	0.00
ТӨСВИЙН ЗАХИРАГЧААС	1,197,641,185.00	1,197,641,185.00	0.00	0.00
Төсвийн ерөнхийлөн захирагч хооронд хийсэн	1,197,641,185.00	1,197,641,185.00	0.00	0.00
ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,339,450,372.66	2,307,832,072.66	-968,381,700.00	0.00
Орон нутгийн төсвөөс	1,339,450,372.66	1,322,057,072.67	17,393,299.99	0.00
ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	828,169,000.00	853,454,384.00	-25,285,384.00	0.00
Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	756,169,000.00	781,454,384.00	-25,285,384.00	0.00
Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	72,000,000.00	72,000,000.00	0.00	0.00
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	227,708,697.49	0.00	227,708,697.49	0.00
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00	997,176,293.65	-997,175,293.65	0.00

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Орхон аймаг дахь Бүсийн оношлогоо эмчилгээний төв нь эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлдэг, Эрүүл мэндийн яамны харьяа байгууллага юм.

Эрүүл мэндийн тухай хуулийн 17 дугаар зүйл, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 13 дугаар зүйлд заасны дагуу тус эмнэлэг нь төрийн өмчит оролцоотой байгууллага юм.

Орхон аймаг дахь Бүсийн оношлогоо эмчилгээний төв нь дараах чиг үүргийг хэрэгжүүлэн ажиллаж байна. Үүнд:

1. Үйлчлэх хүрээний хүн амд үндсэн болон төрөлжсөн нарийн мэргэшлийн лавлагаа тусламжийг үзүүлэх,
2. Үйлчлэх хүрээний хүн амын эрүүл мэндийн байдал, тусламж үйлчилгээний эрэлт хэрэгцээг судлах, анагаах ухааны судалгаа шинжилгээний ажил эрхлэх,
3. Бүс нутгийн түвшинд эмч мэргэжилтний мэдлэг чадварыг тасралтгүй дээшлүүлэх мэргэжил арга зүйгээр хангах зөвлөгөө өгөх хурал семинар, уулзалт зохион байгуулах,
4. Оношилгоо эмчилгээнд дэвшилтэт техник, технологийг нэвтрүүлэх, дотоод гадаадын адил төстэй байгууллага, төвүүдтэй хамтран ажиллах.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Орхон аймаг дахь Бүсийн оношлогоо эмчилгээний төв нь үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд дараах хууль тогтоомжийг мөрдөж байна. Үүнд:

- Эрүүл мэндийн тухай хууль
- Эрүүл мэндийн даатгалын тухай хууль
- Төсвийн тухай хууль,
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Хөдөлмөрийн тухай хууль
- Төрийн албаны тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Нийгмийн даатгалын тухай багц хууль
- Татварын тухай багц хууль
- Хувь хүний орлогын албан татварын тухай хууль

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлогод дараах өөрчлөлтүүд орсон байна. Үүнд:

- Төсвийн тухай хуульд 8 нэмэлт өөрчлөлт
- Төрийн хэмнэлтийн тухай хуульд 3 удаа нэмэлт өөрчлөлт
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд 3 нэмэлт өөрчлөлт
- Хөдөлмөрийн тухай хуульд 2 нэмэлт өөрчлөлт
- Төрийн албаны тухай хуульд 5 удаа нэмэлт өөрчлөлт
- Эрүүл мэндийн тухай хуульд 5 удаа нэмэлт өөрчлөлт
- Эрүүл мэндийн даатгалын тухай хууль 2 удаа нэмэлт өөрчлөлт

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагаа нь үндсэн үйл ажиллагаанд чиглэж, төсөв санхүү, нягтлан бодох бүртгэл, шилэн данс, төрийн хэмнэлтийн тухай хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт хийгээгүй байх тул дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилтийг үр нөлөөгүй гэж дүгнэсэн.

Тус байгууллагын 2024 оны санхүүгийн үйл ажиллагаанд Эрүүл мэндийн яамны хяналт шинжилгээ үнэлгээ, дотоод аудитын газар болон аймгийн Орхон аймгийн Санхүү хяналт дотоод аудитын албанаас хяналт шалгалт хийгээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд тусалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Орхон аймаг дахь Бүсийн оношлогоо эмчилгээний төв нь 2024 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг *аккруэл* сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллага нь захирлын 2014 оны 05 сарын 22-ны өдрийн А/24 дүгээр тушаалаар баталсан, Мишээл-Од Аудит ХХК-ийн боловсруулсан Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг ашиглаж байгаа боловч цаашид чанар, гүйцэтгэлд суурилсан санхүүжилтийн тогтолцоонд шилжиж, Эрүүл мэндийн сайдын багцад нэгтгэгддэг Эрүүл мэндийн яамны байгууллага тул "Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг"-ийг шинэчлэн батлуулж мөрдөх шаардлагатай байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Орхон аймаг дахь Бүсийн оношлогоо эмчилгээний төв нь 2024 оны санхүүгийн тайланг 2024 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2025 оны А/3 дугаар тушаалаар баталсан "Төсөвт байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам"-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн тайлагналтай холбоотой бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 3,051,200.5 мянган төгрөгөөр буюу 7.3 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

			/мянган төгрөгөөр/
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	227,708.7	997,175.3	769,466.60
Авлага	5,291,889.3	2,774,465.7	(2,517,423.6)
Урьдчилгаа	-	-	-
Бараа материал	2,773,884.0	3,056,194.1	282,310.1
нөөцийн бараа	-	-	-

Үндсэн хөрөнгө	33,376,113.2	31,790,559.6	(1,585,553.6)
Нийт хөрөнгө	41,669,595.2	38,618,394.7	(3,051,200.5)
Өр төлбөр	4,050,313.1	3,379,201.3	(671,111.8)
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	37,619,282.1	35,239,193.4	(2,380,088.7)
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	41,669,595.2	38,618,394.7	(3,051,200.5)

Дээрх хүснэгтээс харахад нийт хөрөнгийн дүн өмнөх оны үзүүлэлтээс 7.3 хувиар буурахад авлага 2,517,423.6 мянга, үндсэн хөрөнгө 1,585,553.6 мянган төгрөгөөр тус тус буурсан нь гол нөлөө үзүүлжээ.

Мөнгөн хөрөнгийн дансны үлдэгдэл 769,466.8 мянган төгрөгөөр нэмэгдэж 997,175.3 мянган төгрөг болж өссөн нь төсвийн ерөнхийлөн захирагчаас эрх шилжүүлсэн хөрөнгө оруулалт болох эмгэг судлалын лабораторид нэн шаардлагатай 11 нэр төрлийн багаж техник хэрэгсэл худалдан авах 773,480.0 мянган төгрөгийг 2024 оны 12 дугаар сарын 26-нд шилжүүлсэнтэй холбоотой байна.

Авлагын дансны бууралт 2,517,423.6 мянган төгрөгөөр буюу 52.4 хувиар буурсан нь эрүүл мэндийн даатгалын сангаас авах авлага буурсантай холбоотой байна.

Бараа материалын данс өмнөх оноос 282,310.1 мянган н төгрөгөөр буюу 10.1 хувиар өссөн нь 8,009,672.7 мянган төгрөгөөр бараа материал худалдан авч, 1,021,180.1 мянган төгрөгийн бараа материал үнэ төлбөргүй хүлээн авч, 8,748,542.7 мянган төгрөгийн бараа материал зарцуулсантай холбоотой байна.

Үндсэн хөрөнгийн данс өмнөх оноос 1,585,553.6 мянган төгрөгөөр буюу 4.8 хувиар буурч 31,790,559.6 мянга болсон нь үндсэн хөрөнгө 1,893,754.7 мянган төгрөгөөр нэмэгдэж, 292,723.9 мянган төгрөгийн хөрөнгө хасагдаж, тайлант оны элэгдлийн зардал 3,373,069.1 мянган төгрөг тайлагнасантай холбоотой байна.

Засгийн газрын хувь оролцооны дүн тайлант оны алдагдлаас хамаарч 2,380,088.7 мянган төгрөгөөр буурсан байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2024 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг эрүүл мэндийн даатгалын сангийн төсвөөс 26,069,782.7 мянга, үйл ажиллагааны орлогоос 700,000.0 мянга, туслах үйл ажиллагааны орлогоос 72,000.0 мянга, нийт зарлагыг 26,841,782.7 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас 2,385,910.7 мянган төгрөгөөр бууруулж, 23,683,872.0 мянган төгрөгөөр баталсан байна.

Энэ нь нэг талаас төсвийн төслийг бодитой, үндэслэлтэй боловсруулаагүй, нөгөө талаас төсвийн төслийн саналыг харгалзалгүй үндэслэлгүй бууруулж баталсан байна.